



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

**Хороодын Хамтарсан багийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалын хавсралтын 2.1, 2.2, 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хороодын Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.


2.1 дүгээр хорооны Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, 2 дугаар хорооны Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хууль, тогтоомжийн хүрээнд чиг үүргийг хэрэгжүүлж, хагас жил тутам тайлагнан ажиллахыг Хамтарсан багийн ахлагч нарт үүрэг болгосугай.

4.Хамтарсан багийг арга зүйн удирдлагаар ханган, дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Д.Оюунгэрэл)-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга (М.Давааням)-д тус тус даалгасугай.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ